

АШНамын Дархан-Уул салбарын  
2020 оны 06 дугаар сарын 25-ний  
Өдрийн 2020 A/01 албан тоотын  
хавсралт

## АРДЧИЛАЛ ШИНЭЧЛЭЛИЙН НАМЫН ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ САЛБАР

### 1. ХҮНИЙ ХӨГЖИЛ, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН

Тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэн ажилласанаар иргэдийн эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчин амьдрах, сурч боловсрох эрхийг хангах болно.

#### 1.1. Иргэдийн эрүүл мэнд.

- 1.1.1. Дархан-Уул аймгийн хэмжээнд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх “Эрүүл хүн- Их Монголын баялаг” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.2. Оношлогоо, эмчилгээний чадавхыг сайжруулж иргэд орон нутагтаа НН шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхэд нөлөөлж ажиллана.

#### 1.2. Иргэдийн боловсрол

- 1.2.1. Цэцэрлэг, сургуулийн тоог хүн амын төвлөрөл эрэлт, хэрэгцээ болон гэр хорооллын хөгжлийн төлөвлөгөөнд тулгуурлан нэмэгдүүлэхэд нөлөөлж ажиллана.
- 1.2.2. Олон улсын хэмжээнд зохион байгуулагдах олимпиад, уралдаан, тэмцээнд оролцох оюутан, суралцагч, багш наарт дэйжлэг туслалцаа үзүүлэх, амжилт гаргасан оюутан, суралцагч, багш нарыг урамшуулна.

#### 1.3. Гэр бүл, залуучуудын хөгжил

- 1.3.1. Залуучуудад гэр бүл төлөвлөлт болон гэр булийн эдийн засгийн мэдлэг олгох “Залуу гэр бүл- Хөгжлийн ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.2. Залуу гэр булийг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.3. Залуу гэр булийг дэмжих зорилгоор сан байгуулж, сар бүр тэтгэлэг олгоно.

#### 1.4. Халамж, үйлчилгээ

- 1.4.1. Ахмадад үзүүлэх халамж үйлчилгээ.
- 1.4.2. Ахмад настан халамж үйлчилгээг хууль эрх зүйн хүрээнд бүрэн, түргэн шуурхай авах мэдээллийн сан байгуулна.
- 1.4.3. Багийн ахмадын төвийн үйл ажиллагааг өргөжүүлж ахмад болон залуу үсийн залгамж холбоог бэхжүүлэх, хүүхэд багачуудад хөдөлмөрч, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх цогцолбор төв байхаар зохион байгуулна.
- 1.4.4. Багийн Ахмадын төвийн санхүүгийн асуудлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

#### 1.4.5. Хүүхэд хамгаалал.

- 1.4.6. Хүүхэд бэртэж гэмтэх, амь насаа алдах зэрэг эрсдэлтэй орчин нөхцлийг түргэн шуурхай илрүүлж, эрсдлийг арилгах нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.4.7. Хүүхэд хүмүүжүүлэх, авьяас чадварыг хөгжүүлэх “ЗӨВ МОНГОЛ ХҮҮХЭД” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эцэг, эх болон ахмад настаны оролцоог нэмэгдүүлж БАГШ- ЭЦЭГ ЭХ- АХМАД НАСТАН гэсэн үндэсний уламжлалт хүмүүжлийн алтан гурвалжинг сэргээн хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.4.8. Хөгжлийн бэрхшээлтэй (тусгай хэрэгцээт) иргэдийг дэмжих
- 1.4.9. Хөгжлийн бэрхшээлтэй (тусгай хэрэгцээт) иргэд үйлчилгээний болон бусад байгууллагаар чөлөөтэй үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.4.10. Хөгжлийн бэрхшээлтэй / тусгай хэрэгцээт / хүүхдийн сурч хөгжих орчныг бүрдүүлэх зорилгоор шинэ бүлэг нээх, шинээр цэцэрлэг барих, улмаар ердийн сургууль, цэцэрлэгт сурч хөгжих орчин бүрдүүлнэ.
- 1.4.11. Хөгжлийн бэрхшээлтэй / тусгай хэрэгцээт / иргэн өрхийн үйлдвэрлэл, аж ахуй эрхлэн явуулах тохиолдолд орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.
- 1.4.12. Хөгжлийн бэрхшээлтэй / тусгай хэрэгцээт / иргэдийг үнэ төлбөргүй орон сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

#### 1.5. Орчны эрүүл ахуй, агаарын бохирдол

- 1.5.1. Өрх бүр мод тарих “Нэг айл-Нэг мод” хөтөлбөр болон шинэ төрсөн иргэн бүрд зориулан мод тарьж “Шинэ Иргэн” цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
- 1.5.2. Гэр хорооллын айлын хашаа болон гудамжийг тохижуулах иргэдийн оролцоотой “Миний Дархан-Миний гудамж” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.5.3. Гэр хорооллын нүүрсний утааг багасгах зорилгоор шахмал түлшний үйлдвэрийг байгуулан ажиллахад дэмжлэг үзүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 1.5.4. Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилана.

### 2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, БАТАЛГААТ АЖЛЫН БАЙРЫГ БИЙ БОЛГОНО

Иргэдийн оролцоотой орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжин ажиллах бодлого хэрэгжүүлсэнээр баталгаат ажлын байрыг нэмэгдүүлж, чинээлэг дунд давхаргийг бий болгоно.

#### 2.1. Ядууралтыг бууруулах.

1. Орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоосноор иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.
2. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

#### 2.2. Эдийн засгийг төрөлжүүлийз.

Дархан-Уул аймаг төвийн бүсийг экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой хангах бүс нутаг болох зорилтыг хэрэгжүүлэн ажиллахын хамт эдийн засгийн бусад салбарыг жигд дэмжин ажилласанаар ажлын байрыг шинээр бий болгох зорилтыг дэмжиж ажиллана.

1. Газар тариалан, мал аж ахуйн салбарыг өндөр үр ашигтай, эрчимжсэн байдлаар хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.
2. Газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах:
  - Сүү боловсруулах
  - Арьс, шир боловсруулах
  - Хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэрийг байгуулахад бодлогын зөвлөл ажиллуулна.
3. Экологид ээлтэй, уул уурхайн салбарыг дэмжиж ажиллана.
4. Орон нутгийн онцлогт тулгуурласан аялал жуучлал болон гар урлал, бэлэг дурсгал үйлдвэрлэлийн салбарыг цогц байдлаар хөгжүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.
5. Барилгын үйлдвэрлэлийн салбарыг дэмжиж ажиллана.
6. Технологи болон мэдлэгт сууринсан эдийн засгийн шинэ салбарыг дэмжиж ажиллана.

### 2.3. Хөрөнгө оруулалт

1. Өндөр технологи, ноу-хау бүхий салбарт хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.
2. Газар тариалан, мал аж ахуй бүтээгдэхүүнийг боловсруулах салбарт иргэд хоршоолсон байдлаар хөрөнгө оруулахыг тууштай дэмжиж ажиллана.

### 3. Соёл урлаг

- 3.1. Түүх соёлын дурсгалт болон археологийн олдворт газрыг хамгаалалтанд авч аялал жуучлалын чиглэлээр ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлиэ.
- 3.2. Орон нутгийг судлах музейг шинэ байранд оруулах ажлыг судлан, хэрэгжүүлэх ажлыг дэмжиж ажиллана.
- 3.3. Дархан хотын номын санг шинэ байранд оруулж, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрөөх цогцолбор төв болгох бодлогыг боловсруулан ажиллана.

### 4. Дэд бүтэц

- 4.1. Гэр хорооллын айл өрхийг өндөр хурдны интернет болон юнивишинд холбох ажлын бодлогын түвшинд хэрэгжүүлэхэд нөлөөлнө.
- 4.2. Гэр хорооллын айл өрхийг төвийн шугаманд холбох ажлыг үргэлжлүүлж хашаандаа тав тухтай амьдрах орчныг бүрдүүлиэ.
- 4.3. Үнадаг дугуйн замын сүлжээтэй болох хөтөлбөр төлөвлгөө боловсруулан, хэрэгжүүлэх ажлыг дэмжиж ажиллана.

Ардчилал Шинэчлэлийн нам

Дархан-Уул салбар